



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот.

Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11.

Утас: (976) 51-267168. Факс: (976) 11-312315.

E-mail: info@mrttd.gov.mn, http://www.mrttd.gov.mn

2022.10.04 № 03/4545  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

**Г САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН  
ГАЗАРТ**

Зам, тээврийн хөгжлийн яамны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан “Гранд рөүд групп” ХХК-д Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам”-ын 8.6 дахь заалтын дагуу олгох 21,311,441.0 (хорин нэгэн сая гурван зуун арван нэгэн мянга дөрвөн зуун дөчин нэг) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт: 14 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД



080003305

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт

2022.10.04

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2022 оны эхний үлдэгдэл	2022 онд нэмэгдсэн орлого	2022 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлгэх нийт дүн		28,415,255	0	0	21,311,441	7,103,814		
1	Сумын төвөөс аймгийн төв хүртэлх авто замын засвар, 60 км /Ховд, Дуут сум/	"Грандрөүд групп" ХХК	28,415,255			21,311,441	7,103,814	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018.03.14-ны өдрийн 49 дүгээр тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах журам"-ын 8.6 дахь заалт	Авто зам, замын байгууламжийг байнгын ашиглалтад авах ажлын хэсгийн 2020.08.05-ны өдрийн 01/20 дугаартай акт, дүгнэлт, Ховд аймгийн Дуут сумын Засаг даргын 2022.09.21-ний өдрийн 01/172 тоот албан бичиг

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч

Ч.Ренчиндамба

Н.Баярсайхан



ЗАМ ТЭЭВРИЙН  
ХӨГЖЛИЙН ЯАМАНД

### ГРАНД РӨҮД ГРУПП ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг  
4-р хороо, 11-р хороолол, М11 29 тоот

Гар утас: +976 99999846, 90425555

2022.03.26 № 2022/0231

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хүсэлт гаргах тухай

Манай "Гранд Рөүд Групп" ХХК нь ЗТХЯ201901068 тоот гэрээтэй улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто замын засварын ажлыг 2019 оны 10 сарын 07-нд эхлүүлж 2020 оны 08 дугаар сарын 05-н улсын комисст хүлээлгэж өгсөн билээ. Уг засварын ажлын баталгаат хугацаа болох 2 жилийн хугацаа нь дууссан бөгөөд энэ хугацаанд тухайн авто замд ямар нэгэн эвдрэл гараагүй хэвийн ашиглагдаж байна.

Иймд тухайн ажлын баталгааны барьцаанд буй 28,476,317 төгрөгийг чөлөөлж манай компанийн Капитрон банкин дахь 3005026806 тоот данс руу шилжүүлж өгнө үү.

ЗАХИРАЛ:



Б.АХЫНБЕК



ХОВД АЙМАГ  
ДУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

84200 Босго, Дуут сум, Ховд аймаг

᠒᠐᠒᠒.᠐᠑.᠒᠒ № 1/17᠒  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
ЯАМАНД

Хүсэлт уламжлах тухай

"Грандрөүд групп"ХХК нь Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60км зам засварын ажил ЗТХЯ 201901068 тендерийн дугаар бүхий ажлыг 2019.10.07-2022.08.06-ны хооронд гүйцэтгэн улсын комисст хүлгээлгэн өгсөн бөгөөд уг зам нь хэвийн ашиглагдаж байна.

Иймд тендерийн гүйцэтгэлийн баталгааны 5% -ийн барьцаа болох 28,476,317 төгрөгийг чөлөөлөхөд татгалцах зүйлгүй болно.

ДАРГА



С. ГАНЗОРИГ



**ГҮЙЦЭТГЭГЧ:**  
"ГРАНД РӨҮД ГРУПП" ХХК-НИЙ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Б.АХЫНБЕК

*Тамга, гарын үсэг*

**ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ТӨВӨӨС АЙМГИЙН ТӨВ ХҮРТЭЛХ  
60 КМ ЗАМЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ГЭРЭЭНИЙ СУНГАЛТ**

**ЗТХЯ/201901068**

2020.06.12

Ховд аймаг

Нэг талаас [Засаг даргын тамгын газар] (цаашид "захиалагч" гэх); нөгөө талаас "ГРАНД РӨҮД ГРУПП" ХХК (цаашид "гүйцэтгэгч" гэх) харилцан тохиролцож 2020 оны 07 сарын 13-ны өдөр хүртэл энэхүү гэрээний хугацааг (цаашид "гэрээ" гэх) сунгав.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА *Б.БАЯРСҮХ*

**ЗАХИАЛАГЧИЙН ТӨЛӨӨЛЖ:**  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХӨРӨНГӨ, ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН  
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Ц.СУВДАА

*Ц.Сувдаа*  
*Д.Батгэрэл* Д.БАТГЭРЭЛ

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**  
"ГРАНД РӨҮД ГРУПП" ХХК-НИЙ  
ИНЖЕНЕР

*Н.Энхбат* Н.ЭНХБАТ  
ХАЯГ: УЛААНБААТАР,  
БЗД, 4-Р хороо, 15-р хороолол,  
мэргэжилтэн 41, 23 тоот  
Утас: 99999846, 99432100  
Харилцах банк: Голомт банк  
Дансны дугаар: 5805112212  
РД: 5693306



Захиалагчийг төлөөлж:

*Ц.Сувдаа*

Гүйцэтгэгчийг төлөөлж:

*Н.Энхбат*

БАТЛАВ.



ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ТӨВӨӨС АЙМГИЙН ТӨВ  
ХҮРТЭЛХ 60 КМ ЗАМЫН ЗАСВАРЫН АЖИЛ

Дугаар: ЗТХЯ/201901068

2019 оны 10 сарын 07-ны өдөр

Ховд

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Нэг талаас [Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Грандрөүд групп” ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2019 оны 10 сарын 07-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

2. Монгол Улсын Иргэний, барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хоёр. Гэрээний хугацаа

2.1. Гүйцэтгэгч нь Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км зам засварын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдөр эхэлж, 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулна.

2.2. Энэхүү гэрээ нь Талуудын бүрэн эрхт төлөөлөгч гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс хүчин төгөлдөр болж энэхүү гэрээний тусгай нөхцөлд заасан баталгаат хугацаа дууссанаар дуусгавар болно.

М.Гүвдэн

Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

Б.Ахь Ибек

Гүйцэтгэгчийг төлөөлж

2.3. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээнд дурдсан ажлуудыг үе шатны хуваарьт заасан хугацаанд хийж гүйцэтгэн захиалагчид албан бичгээр танилцуулж харилцана.

2.4. Захиалагч нь үе шатны хуваарийн дагуу ажлаа гүйцэтгэж тайлагнаагүй болон ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэхгүй зэрэг шалтгаанаас харилцан ойлголцохгүй бол гэрээг цуцлах үндэслэл болно.

2.5. Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд доголдол байвал Захиалагч нь ажлыг хүлээн авснаас хойш 10 /арав/-н хоногийн дотор, харин ажлыг хүлээн авах үед илрүүлэх боломжгүй дутагдлын тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш 3 /гурван/-н жилийн дотор гаргана.

#### Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Захиалагч нь гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ажил эхлэх техникийн нөхцөл, шаардлагатай заавар, зааварчилгаа, ажлын зураг, төсөв, ажлын даалгавар, тоо хэмжээ зэрэг бичиг баримтыг бэлэн болгон гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

3.2. Ажлын зурагт ашиглагч, захиалагч байгууллагын хүсэлтийн дагуу зохиогчийн зөвшөөрөлтэй өөрчлөлт оруулах саналыг гүйцэтгэгчид хүргүүлж, 2 тал зөвшилцөн шийдвэрлэнэ.

3.3. Ажлын тоо хэмжээ, зураг төсөв болон Захиалагчаас өгсөн ажлын даалгавартай тохирч байгаа эсэхийг шалган, үе шатны ажил бүрт техникийн хяналтыг байнга тавин, үе шатны ажил бүрийг гүйцэтгэгчээс актаар хүлээн авч гүйцэтгэгчийн гаргасан далд ажлын актыг хянан баталгаажуулна.


3.4. Ажлын гүйцэтгэлийг тухай бүр хянаж, ажил дууссаны дараа ажлын акт, дүгнэлт, гүйцэтгэлээр хүлээн авах бөгөөд зураг төсөв, ажлын даалгаварыг зөрчиж буруу, дутуу, чанаргүй хийсэн ажлыг тогтоосон хугацаанд засах гүйцээн хийхийг шаардах, гарсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

3.5. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн эсвэл удаа дараа хангалтгүй биелүүлсэн бол ажлыг хүлээн авч санхүүжилтээс татгалзаж, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй.


3.6. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын явцыг Шилэн дансны цахим сайтад байршуулах талаар зөвлөмж өгнө.

3.7. Ажил гүйцэтгэсэн төлбөрийг энэхүү гэрээнд заасан гүйцэтгэлийн баримтыг үндэслэн олгоно.

3.8. Хууль тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

  
Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

  
Гүйцэтгэгчийг төлөөлж

Дөрөв. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1. Гүйцэтгэгч нь ажлыг захиалагчийн өгсөн ажлын зураг, төсөв, даалгавар, тоо хэмжээ, техникийн нөхцөлийн дагуу заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэнэ.

4.2. Гүйцэтгэгч нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй барилгын норм, дүрэм, стандарт, технологийн шаардлагын дагуу ажлыг гүйцэтгэнэ.

4.3. Гэрээнд заасан засвар хийх ажлыг хэрэгжүүлэхэд тухайн объектын хуучин материалыг ашиглагч талд бүрэн хүлээлгэн өгнө.

4.3. Ажлыг гүйцэтгэлийн явцад захиалагчаас өгөх зааварчилгаа, мэдээллийг хангалтгүй байна гэж үзвэл сайжруулахыг шаардах эрхтэй, ажлыг гүйцэтгэх үед тодорхой бус байдал, захиалагчийн болон бусдын эд хөрөнгөд эвдрэл, гэмтэл, осол, бусад хохирол учирч болохуйц эргэлзээтэй нөхцөл байдал бий болсон буюу болох нь тодорхой үед ажлыг түр зогсоож захиалагчид мэдэгдэнэ.

4.4. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх явцад гарсан аливаа эвдрэл гэмтлийг бүрэн хариуцах бөгөөд энэхүү хугацаанд ямар нэгэн эвдрэл гарвал холбогдох зардлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

4.5. Гүйцэтгэсэн ажил дуусахаас 3 хоногийн өмнө захиалагч талд албан бичгээр мэдэгдэх ба ажил дууссаны дараа захиалагчийн томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

4.6. Гүйцэтгэгч нь актаар хүлээлгэн өгсөн ажлын төлбөрийг энэхүү гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг захиалагч талаас шаардах эрхтэй.

4.7. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, ажлын явцыг Шилэн дансны цахим сайтад байршуулж ил тод мэдээлнэ. /www.shilendans.gov.mn, лавлах утас 71001111/


4.8. Гэрээний хавсралтанд заасан заалтуудыг мөрдөн хэрэгжүүлнэ.

4.9. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд заасан хугацаанаас хоцроолгүй гүйцэтгэлийн баталгааг гэрээний үнийн [5 хувьтай]–тай тэнцүү дүнгээр ирүүлнэ.

4.10. Хууль тогтоомжид заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.


Тав. Гэрээний үнэ, санхүүжилтийн эх үүсвэр, төлбөр

5.1. Захиалагч нь Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км зам засварын ЗТХЯ/201901068 гэрээний дугаартай ажлыг (цаашид "ажил" гэх) 569 526 340 /Таван зуун жаран есэн сая таван зуун хорин зургаан мянга гурван зуун дөч/ төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн



Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:



Гүйцэтгэгчийг төлөөлж

тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

5.2. Ажил нь Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ний өдрийн 388 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 08 дугаар тушаал, Монгол Улсын 2019 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтын 2 дугаар хавсралтын XIII.1.2.13 -аас санхүүжинэ.

5.3. Гэрээний нийт санхүүжилт: **569 526 340 төгрөг** ба **2019** онд **350 000 000** төгрөг, **2020** онд **219 526 340** төгрөг.

5.3.1. Гэрээний санхүүжилтийг 2019 онд **/50/50/** харьцаагаар олгоно.

5.3.2. Эхний санхүүжилт буюу ажлын төлбөрийг иж бүрэн гэрээ, ажлын зураг, даалгавар, төсөв, ажил гүйцэтгэх үе шатны хуваарь, гүйцэтгэл, гүйцэтгэлийн фото зураг, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн **50** хувь буюу **175 000 000** төгрөгийн санхүүжилт олгоно.

5.3.3. Явцын санхүүжилт буюу ажлын төлбөрийг иж бүрэн гэрээ, ажлын зураг, даалгавар, төсөв, ажил гүйцэтгэх үе шатны хуваарь, гүйцэтгэл, гүйцэтгэлийн фото зураг, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн **50** хувь буюу **175 000 000** төгрөгийн санхүүжилт олгоно.


5.3.4. Гэрээний санхүүжилтийг 2020 онд **/50/50/** харьцаагаар олгоно.

5.3.5. Явцын санхүүжилт Явцын санхүүжилт буюу ажлын төлбөрийг иж бүрэн гэрээ, ажлын зураг, даалгавар, төсөв, ажил гүйцэтгэх үе шатны хуваарь, гүйцэтгэл, гүйцэтгэлийн фото зураг, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн **50** хувь буюу **109 763 170** төгрөгийн санхүүжилт олгоно.


5.3.6. Эцсийн санхүүжилт буюу ажлын төлбөрийг албан бичиг, ашиглалтанд хүлээн авсан улсын комиссын акт, дүгнэлт, ил, далд ажлын акт, хурлын тэмдэглэл, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын болон төсвийн гүйцэтгэл, ажил гүйцэтгэх үе шатны хуваарийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлүүд бүгд албан баталгаажсан, гүйцэтгэсэн ажлын зургийг өнгөтөөр хэвлэмэл, холбогдох бусад бичиг баримтыг үндэслэн **50** хувь буюу **109 763 170** төгрөгийн санхүүжилт олгоно.

#### Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

  
Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

  
Гүйцэтгэгчийг төлөөлж

6.2. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг давхар хүлээнэ.

6.3. Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон бол алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн [0,05 хувь], алдангийн нийт хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн [5] хувь байна.

6.4. Чанарын баталгаат хугацаа [1080]<sup>1</sup> хоног, барьцаа хөрөнгийн дүн [5] хувь байх бөгөөд захиалагч нь гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн төлбөр бүрээс суутгаж, ажил бүрэн дууссаны дараа 50 хувийг, үлдэх 50 хувийг чанарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгчид арилгасан тухай мэдэгдлийг үндэслэн олгоно.

6.5. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

6.6. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

#### Долоо. Гэрээний хавсралтууд

7.1. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;

Тендер;

Гэрээний тусгай нөхцөл;

Техникийн тодорхойлолт, ажлын даалгавар;

Зураг, Төсөв

Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь<sup>3</sup>;

Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, захирлын иргэний үнэмлэхийн хуулбарууд

#### ГЭРЭЭГ БОЛОВСРУУЛСАН:

ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

*М. Сувдаа* /Ц.СУВДАА

<sup>1</sup> Энэ хугацааг ихэвчлэн Иргэний хуульд нийцүүлж авна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

<sup>3</sup> Нэгж үнийн гэрээнд "үе шатны ажлын хуваарь" гэснийг "ажлын тоо хэмжээ" гэж солино.

*М. Сувдаа*  
Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:

*Ц. Сувдаа*  
Гүйцэтгэгчийг төлөөлж

ГЭРЭЭГ ХЯНАСАН:

ХЭЗХ-ИЙН ДАРГА



/Н.ГАНЗОРИГ/

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХОХБТХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР

ӨРЛӨН ГҮЙЦЭТГЭГЧ



/Ц.ГАНДАНДОВРОН/

ХОХБТХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

П/О

/Д.БАТГЭРЭЛ/

УТАС: 70432423, 99436009

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ГРАНДРӨҮД ГРУПП" ХХК-НИЙ  
ИНЖЕНЕР



/Ё.АЮУРЗАНА/


Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4-р  
хороо, 15-р хороолол, мэргэжилтэн  
41, 23 тоот.

Утас: 99999846, 99432100

Харилцагч банк: Голомт банк


Дансны дугаар: 5805112212

Регистрийн дугаар: 5693306



Захиалагчийг төлөөлж

Хуудсыг баталгаажуулсан:



Гүйцэтгэгчийг төлөөлж

**ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ТӨВӨӨС АЙМГИЙН  
ТӨВ ХҮРТЭЛХ 60 КМ ЗАМ ЗАСВАРЫН АЖЛЫГ  
БАЙНГЫН АШИГЛАЛТАД АВАХ  
УЛСЫН КОМИССЫН АКТ, ДҮГНЭЛТ**

2020 оны 08 сарын 05-ны өдөр

Дугаар 01/20

Ховд хот

**НЭГ. Ерөнхий мэдээлэл**

1.1. Объектын нэр: **Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажил.**

1.2. Хүчин чадал, байршил, хэмжээ, үндсэн хийц бүтээц: **60 км урт, 6 метрийн өргөн ердийн хөрсөн зам. Нийт 11 байршилд Ø1000 төмөр бетон хос хоолой 1 ширхэг, Ø1000 дан төмөр бетон хоолой 10 ширхэг. Ховд аймгийн Дуут сум.**

Хаяг: **Ховд аймаг /нийслэл/, Дуут сум /дүүрэг/, Шивэр баг, ... баг /хороо/,  
..... гудамж /хороолол/**

1.3. Ерөнхий гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: **“Гранд рөүд групп” ХХК, Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 4-р хороо, 11-р хороолол, М11 29 тоот.**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **Рд: 5693306**

1.4. Гүйцэтгэгч байгууллагын нэр, хаяг: .....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: .....

1.5. Зураг төсөл боловсруулсан байгууллагын нэр, хаяг: **“Тарваченбүүлэн ХХК”, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 17-р хороо, АОС-50.**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **Рд: 5532361**

1.6. Захиалагч байгууллагын нэр, хаяг: **Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар, Ховд аймгийн Жаргалант сум, Жаргалан баг, Нутгийн удирдлагын ордон.**

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр: **Рд: 9067043**.....

1.7. Техник, технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч байгууллагын нэр, хаяг: .....

Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, регистр:

1.8 **Аймгийн Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 31-ны өдрийн А/415 дугаар захирамжаар батлагдсан шийдвэрээр зохион байгуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг нь Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажлыг ашиглалтад оруулахад бэлэн болсон тухай “Гранд рөүд групп” ХХК – ний байгууллагын 2020 оны 07 сарын 10 - ны өдрийн 26 дугаар мэдэгдлийн дагуу 2020 оны 08 сарын 05 - ны өдрөөс 06 - ны өдрүүдэд шинээр барьсан /их засвар, өргөтгөл/ шинэчлэлтийн ажлын чанар,**

холбогдох акт, баримтуудтай танилцаж, газар дээр нь ажиллаж, үзлэг шалгалт хийв.

1.9. Энэхүү Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажлыг 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс гүйцэтгэж эхэлсэн бөгөөд 2020 оны 07 сарын 10 - ны өдөр бүрэн дуусгасан байна.

### **ХОЁР. Ажлын хэсгийн шийдвэр**

Энэхүү Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажлыг холбогдох бичиг, баримт, ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр ашиглалтад оруулах Ажлын хэсгээс ШИЙДВЭРЛЭСЭН нь:

2.1. Энэхүү Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажил нь бүрэн хийгдэж Дуут сумын иргэд аймгийн төвөөс сумын төв рүү ердийн хөрсөн замаар саадгүй зорчих зориулалтаар ашиглахад боломжтой гэж үзээд захиалагч байгууллага болох аймгийн Засаг даргын Тамгын газар, ашиглагч (хариуцагч) байгууллага Дуут сумын Засаг даргын Тамгын газар – ын мэдэлд 2020 оны 08 дугаар сарын 05 - ны өдрөөс ашиглалтад оруулахыг зөвшөөрөв.

2.2. Уг Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын угсралтын ажлын үндсэн хөрөнгийг 569 526 340 /Таван зуун жаран есөн сая таван зуун хорин зургаан мянга гурван зуун дөч/ төгрөгөөр үнэлэв.

2.3. Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажлыг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан Ажлын хэсгээс даалгах нь:

#### Гүйцэтгэгч байгууллагад.

1. Техникийн баримт бичгийн бүрдлийг хангаж, техник, технологийн хяналтын зөвлөх байгууллагаар хянуулан архивд эх хувийг үлдсэн хувийг тухайн байгууламжийн эзэмшигч, хариуцагч байгууллагад ... хоногийн дотор хүлээлгэж өгч, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэх ажлыг хийх,

2. Гүйцэтгэгч, техник, технологийн хяналтын зөвлөх байгууллага байгууламжийг ашиглалтад хүлээн авснаас хойш чанарын баталгааны 3 жилийн хугацаанд тухайн Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварт илэрсэн чанараас шалтгаалсан технологийн эвдрэл гэмтлийг бүрэн хариуцах.

#### Хариуцагч (ашиглагч) байгууллагад:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газар нь уг ажлыг цаашид хариуцах Дуут сумын Засаг даргын Тамгын газар – т өмчийг /хөрөнгийг/ хүлээлгэн өгөх.

2. Чанарын баталгаат хугацаа дууссанаас хойш Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ашиглалтын бэлэн байдал, техникийн аюулгүй байдлыг бүрэн хангаж, арчлалт, засвар үйлчилгээг тогтмол хийж байх.

3. Ажлын хэсгийн акт 4 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, техникийн баримт бичигт хавсаргав.

### ГУРАВ. Актын баталгаажуулалт

Ховд аймгийн Дуут сумын төвөөс аймгийн төв хүртэлх 60 км авто зам засварын ажлыг ашиглалтад авах дүгнэлт гаргасан:

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга:

Б.Баярсүх – аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Балжинням – Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн хошууч



Б.Ганзориг – Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч

Б. Ариундолгор



Б.Ариундолгор - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

А.Энхбаяр – Дуут сумын Засаг дарга

Х.Соронзонболд – Дуут сумын Шивэр багийн Засаг дарга

ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ТӨВӨӨС  
АЙМГИЙН ТӨВ ХҮРТЭЛХ 60 КМ  
АВТО ЗАМ ЗАСВАРЫН АЖИЛ

*Л. Алтанцэцэг*

Л.Алтанцэцэг – Дуут сумын Байгаль орчны  
хяналтын улсын байцаагч

*З. Виктор*

З.Виктор – Дуут сумын иргэдийн төлөөлөл

Нарийн бичгийн дарга:

*Ц. Сувдаа*

Ц.Сувдаа – Хөрөнгө оруулалт, хөгжлийн  
бодлого төлөвлөлтийн хэлтсийн зам  
тээвэр, уул уурхай, хүнд үйлдвэрийн  
хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн